



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2020 оны 04 сарын 21 өдөр

Дугаар 168

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгийн ашиглалтын
хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эмгэг судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглаж болох нийт 4 нэрийн 43,974,900.00 /дөчин гурван сая есөн зуун далан дөрвөн мянга есөн зуун/ төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 8,090,632.00 /найман сая ерэн мянга зургаан зуун гучин хоёр/ төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Я.Амаржаргал, Эмгэг судлалын үндэсний төвийн захирал Г.Уянга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



З.МЭНДСАЙХАН

Д.НАРАНГЭРЭЛ

000031

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн
168 дугаар тогтоолын хавсралт

Эмгэг судлалын үндэсний төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй,
үлдэгдэл өртөггүй, ашиглах хугацааг сунгаж үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, төрөл	Ашиглалтад орсон огноо	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт балансын үнэ /хуримтлагдсан элэгдэл/ (төгрөг)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)			Цаашид ашиглах хугацаа (жилээр)
						Нэг бүрийн үнэ (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт үнэ (төгрөг)	
1	Туксон, 28-97 УНТ	2012-08-20	35,207,000.00	1	35,207,000.00	7,465,188.00	1	7,465,188.00	2
2	Хөргөгч	2013-09-17	489,900.00	1	489,900.00	139,844.00	1	139,844.00	2
3	Бодисны шкаф	2009-11-30	478,000.00	1	478,000.00	95,600.00	1	95,600.00	2
4	Тавиур шил хадгалах шүүгээ	2009-12-28	1,950,000.00	4	7,800,000.00	97,500.00	4	390,000.00	2
	Нийт дүн		38,124,900.00	8	43,974,900.00 /дөчин гурван сая есөн зуун далан дөрвөн мянга есөн зуун/	7,798,132.00	8	8,090,632.00 /найман сая ерэн мянга зургаан зуун гучин хоёр/	